



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠢᠰᠢᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠢᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А1507

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хүүхдийн эрхийг хамгаалах-Олон Улсын өдөр"-ийг "Нэгдүгээрт хүүхэд" уриан дор хүүхдийн эрхийг хангах, тэдний авьяас, билгийг хөхүүлэн дэмжих чиглэлээр хүүхдийн санал санаачилгыг өрнүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхжаргал - (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: С.Цагаанбаатар - (Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Эрдэнэ-Очир - (Цагдаагийн газрын дарга)

Н.Сумьяабазар - (Мэргэжлийн хяналтын газрын дарга)

Ж.Амгаланбаатар - (аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Алтанхуяг - (Есөнбулаг сумын Засаг дарга)

Э.Отгонбаатар - (Ардын дуу бүжгийн "Алтай" чуулга"-ын дарга)

М.Эрдэнэбилэг - (Хүүхдийн элч)

Нарийн бичгийн дарга: Б.Алтайбаатар - (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

2.Тус арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын удирдамж, хөтөлбөр боловсруулан үр дүнтэй зохион байгуулж, Хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.АМГАЛАНБААТАР

